БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/148/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2022 оны 02 дугаар сар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. Аудитын тайлан ........ 10
**3.1 Ерөнхий зүйл** ........ 10
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ........ 10
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 11
**3.4 Материаллаг байдал** ........ 11
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ........ 11
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 12
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ........ 13
**3.8 Аудитын гол асуудал** ........ 13
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 13
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 13
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 14
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
4.1 Залруулсан алдаа ........ 14
4.3 Зөвлөмж ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ<br>ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn
2022.02.16 № 2/05

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх



0050?0185

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,286,363.42** | **32,586,144.42** |
| **33** | **АВЛАГА** | 5,500,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 5,500,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,500,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 40,786,363.42 | 32,586,144.42 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 55,346.00 | 55,346.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 40,731,017.42 | 32,530,798.42 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,290,700.00 | 809,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,742,300.00 | 1,994,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,250,000.00 | 5,250,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,200,087.42 | 87.42 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,247,930.00 | 24,476,711.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **470,916,942.08** | **567,803,518.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 470,916,942.08 | 567,803,518.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 448,362,608.94 | 537,186,685.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 195,394,386.72 | 195,394,386.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -10,195,244.83 | -14,896,200.55 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 240,191,750.00 | 172,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -91,594,527.82 | -39,761,111.18 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 374,037,949.31 | 327,430,318.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -273,873,273.84 | -120,602,678.36 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,287,773.00 | 35,483,793.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,886,203.60 | -18,561,822.29 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 22,554,333.14 | 30,616,833.31 |
| 39301 | Програм хангамж | 1,790,000.00 | 1,580,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,760,666.86 | -988,166.69 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,525,000.00 | 30,025,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **517,203,305.50** | **600,389,663.07** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **175,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 175,000.00 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 175000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 175,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **517,203,305.50** | **600,214,663.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 517,203,305.50 | 600,214,663.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 328,802,027.70 | 328,802,027.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 328,802,027.70 | 328,802,027.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 124,595,322.53 | 209,518,515.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 124,595,322.53 | 126,507,158.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 83,011,357.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 63,805,955.27 | 61,894,119.75 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **517,203,305.50** | **600,389,663.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,444,172,299.65** | **836,892,339.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **630,522,937.67** | **247,119,601.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 630,522,937.67 | 247,119,601.36 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 630,522,937.67 | 71,084,233.36 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 569,223,244.00 | 71,084,233.36 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 61,299,693.67 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **261,368,761.98** | **62,510,838.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 552,280,600.00 | 527,261,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 232,575,861.98 | 30,967,768.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 227,575,861.98 | 27,967,768.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,792,900.00 | 30,124,570.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,792,900.00 | 30,124,570.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 1,418,500.00 |
| 133003 | Хөрөнгийн | 00.00 | 1,418,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,268,203,104.59** | **753,880,981.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,268,203,104.59** | **753,880,981.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 614,089,614.01 | 670,484,636.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 406,478,073.66 | 406,195,742.53 |
| 210101 | Үндсэн цалин | 297,324,521.66 | 405,240,869.86 |
| 210102 | Нэмэгдэл | 86,526,899.00 | 380,872.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,880,100.00 | 574,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 11,746,553.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,169,354.76 | 52,514,561.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,814,947.02 | 36,422,430.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,180,008.62 | 4,108,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,246,499.68 | 2,965,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 811,599.69 | 753,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,116,299.75 | 8,264,830.63 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,212,513.00 | 22,304,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,425,496.00 | 2,438,480.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,351,057.00 | 17,430,060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,435,960.00 | 2,435,960.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,535,181.00 | 26,882,379.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,649,000.00 | 8,229,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,843,150.00 | 8,855,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 479,600.00 | 713,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,337,400.00 | 3,353,800.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 468,240.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,226,031.00 | 5,262,439.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 396,000.00 | 192,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 192,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 9,067,570.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 444,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 8,623,070.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,747,000.00 | 15,910,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,747,000.00 | 15,910,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,367,689.98 | 29,145,724.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,787,661.98 | 28,561,124.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 268,900.00 | 268,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 212,128.00 | 216,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,183,801.61 | 108,271,159.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,960,815.67 | 19,568,468.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 42,222,985.94 | 88,702,691.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 654,113,490.58 | 83,396,345.36 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,524,111.00 | 3,016,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 39,902.00 | 00.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,341,609.00 | 3,016,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,142,600.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 544,723,244.00 | 75,773,077.36 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 544,649,244.00 | 75,773,077.36 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,580,387.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,580,387.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,285,748.58 | 4,607,268.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,285,748.58 | 4,607,268.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 70,000,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **175,969,195.06** | **83,011,357.57** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **175,969,195.06** | **83,011,357.57** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 328,802,027.70 | 63,805,955.27 | -51,373,872.53 | 341,234,110.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **-51,373,872.53** | 341,234,110.44 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 175,969,195.06 | 175,969,195.06 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **124,595,322.53** | 517,203,305.50 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **124,595,322.53** | 517,203,305.50 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,911,835.52 | 1,911,835.52 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **328,802,027.70** | **63,805,955.27** | **126,507,158.05** | 519,115,141.02 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,911,835.52 | 00.00 | -1,911,835.52 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 83,011,357.57 | 83,011,357.57 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **328,802,027.70** | **61,894,119.75** | **209,518,515.62** | 600,214,663.07 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,382,872,605.98** | **664,938,471.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **569,223,244.00** | **71,084,233.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 569,223,244.00 | 71,084,233.36 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 569,223,244.00 | 71,084,233.36 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 569,223,244.00 | 71,084,233.36 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **813,649,361.98** | **593,854,238.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 552,280,600.00 | 527,261,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 232,575,861.98 | 36,467,768.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 227,575,861.98 | 33,467,768.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,792,900.00 | 30,124,570.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,792,900.00 | 30,124,570.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,222,376,605.98** | **654,339,071.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,222,376,605.98** | **654,339,071.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **568,164,626.40** | **570,942,726.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 406,478,073.66 | 403,660,810.00 |
| 210101 | Үндсэн цалин | 297,324,521.95 | 292,483,610.53 |
| 210102 | Нэмэгдэл | 86,526,898.71 | 86,526,899.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,880,100.00 | 10,880,100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 11,746,553.00 | 13,770,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,169,354.76 | 54,874,494.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,936,755.27 | 38,615,494.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,058,200.37 | 4,064,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,246,499.68 | 3,251,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 811,599.69 | 812,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,116,299.75 | 8,129,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,212,513.00 | 22,304,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,425,496.00 | 2,438,480.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,351,057.00 | 17,430,060.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,435,960.00 | 2,435,960.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,281,950.00 | 15,496,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,649,000.00 | 4,793,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,843,150.00 | 8,855,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 455,500.00 | 713,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,334,300.00 | 1,134,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 396,000.00 | 343,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 343,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 7,820,070.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 7,820,070.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,747,000.00 | 14,149,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,747,000.00 | 14,149,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,225,189.98 | 32,363,524.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 30,645,161.98 | 31,778,924.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 268,900.00 | 268,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 212,128.00 | 216,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,654,545.00 | 19,930,428.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,654,545.00 | 19,930,428.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **654,211,979.58** | **83,396,345.36** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,622,600.00 | 3,016,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,480,000.00 | 3,016,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,142,600.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 544,649,244.00 | 75,773,077.36 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 544,649,244.00 | 75,773,077.36 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,654,387.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,580,387.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,285,748.58 | 4,607,268.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,285,748.58 | 4,607,268.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 70,000,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **160,496,000.00** | **10,599,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **160,496,000.00** | **10,599,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **160,496,000.00** | **10,599,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 160,496,000.00 | 10,599,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 160,496,000.00 | 10,599,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-160,496,000.00** | **-10,599,400.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 557,389,500.00 | 552,779,202.00 | 4,610,298.00 | 99% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 557,389,500.00 | 552,779,202.00 | 4,610,298.00 | 99% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 554,373,500.00 | 549,763,202.00 | 4,610,298.00 | 99% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 406,478,500.00 | 403,660,810.00 | 2,817,690.00 | 99% |
| 210101 | Үндсэн цалин | 295,301,300.00 | 292,483,610.53 | 2,817,689.47 | 99% |
| 210102 | Нэмэгдэл | 86,526,900.00 | 86,526,899.47 | 0.53 | 100% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,880,100.00 | 10,880,100.00 | 0.00 | 100% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,770,200.00 | 13,770,200.00 | 0.00 | 100% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,874,500.00 | 54,874,494.00 | 6.00 | 100% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,615,500.00 | 38,615,494.00 | 6.00 | 100% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,064,700.00 | 4,064,700.00 | 0.00 | 100% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,251,800.00 | 3,251,800.00 | 0.00 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 812,900.00 | 812,900.00 | 0.00 | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,129,600.00 | 8,129,600.00 | 0.00 | 100% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,304,500.00 | 22,304,500.00 | 0.00 | 100% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,400,000.00 | 2,438,480.00 | -38,480.00 | 102% |
| 210302 | Түлш, халаалт | 17,479,500.00 | 17,430,060.00 | 49,440.00 | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,425,000.00 | 2,435,960.00 | -10,960.00 | 100% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,506,900.00 | 15,496,400.00 | 10,500.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 4,801,700.00 | 4,793,400.00 | 8,300.00 | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,857,400.00 | 8,855,200.00 | 2,200.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 713,600.00 | 713,600.00 | 0.00 | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,134,200.00 | 1,134,200.00 | 0.00 | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | 343,200.00 | 343,000.00 | 200.00 | 100% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 343,200.00 | 343,000.00 | 200.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,823,100.00 | 7,820,070.00 | 3,030.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 7,823,100.00 | 7,820,070.00 | 3,030.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 15,484,400.00 | 14,149,500.00 | 1,334,900.00 | 91% |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,484,400.00 | 14,149,500.00 | 1,334,900.00 | 91% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 584,600.00 | 584,600.00 | 0.00 | 100% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 99,000.00 | 99,000.00 | 0.00 | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 268,900.00 | 268,900.00 | 0.00 | 100% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 216,700.00 | 216,700.00 | 0.00 | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30973800.00 | 30529828.00 | 443,972.00 | 99% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,973,800.00 | 30,529,828.00 | 443,972.00 | 99% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3016000.00 | 3016000.00 | 0.00 | 100% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,016,000.00 | 3,016,000.00 | 0.00 | 100% |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,016,000.00 | 3,016,000.00 | 0.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 557,389,500.00 | 552,779,202.00 | 4,610,298.00 | 99% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 527,261,900.00 | 522,654,632.00 | 4,607,268.00 | 99% |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 527,261,900.00 | 522,654,632.00 | 4,607,268.00 | 99% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,127,600.00 | 30,124,570.00 | 3,030.00 | 100% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,127,600.00 | 30,124,570.00 | 3,030.00 | 100% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 40.00 | 38.00 | 2.00 | 95% |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34.00 | 32.00 | 2.00 | 94% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100% |
| 620004 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **232,575,861.98** | **36,467,768.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **232,575,861.98** | 36,467,768.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 232,575,861.98 | 36,467,768.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 187,075,861.98 | 31,778,924.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **45,500,000.00** | 4,668,844.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 45,426,000.00 | 4,668,844.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 74,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 232575861.98 | 36,467,768.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 232,575,861.98 | 36,467,768.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 227,575,861.98 | 33,467,768.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа бараа материалын үнийг тодорхой тусгах, онцгой комиссоос олгож байгаа зардлын анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын шийдвэрийг бүрэн байршуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Тайланд жилд санхүүгийн баримтад нэг дүгээр гарын үсгийн дарга Д.Алтангэрэл, хоёр дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Гэрэлмаа 2021 оны 1-8 болон 11-12 сард, Б.Бүжинлхам 9-10 сард нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн ГХБХБГ–ын үйл ажиллагааны чиглэл нь иргэдэд газар, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн болон газрын кадастрын талаарх төрөөс үзүүлэх үйлчилгээг ил тод, шударга, хөнгөн шуурхай үзүүлж, тэдний эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршдог ба Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас "Газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх жил" нэрэмжит жил болгон зарлаж Газрын удирдлагын цахим систем Egazar.gov.mn сайт болон Egazar.gov.mn гар утасны аплейкшныг хэрэгцээнд нэвтрүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн ГХБХБГ дотоод аудитын нэгж дотоод аудитын чиг үүргийг ГЗБГЗЗГ хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд ГЗБГЗЗГ-аас хяналт шалгалт хийгдсэн боловч хяналт шалгалтын тайлан ирээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж аваагүй, аудитад ашиглах баримт материал байхгүй байсан ба дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардал 557,207.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,358.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,268.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 8,479.2 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 600,389.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 83,186.4 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*Мян.төг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 46,286.4 | 32,586.1 | (13,700.2) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 5,500.0 | - | (5,500.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 40,786.4 | 32,586.1 | (8,200.2) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 470,916.9 | 567,803.5 | 96,886.6 |
| Үндсэн хөрөнгө | 865,226.9 | 762,613.5 | (102,613.4) |
| Хуримтлагдсан элэгдэл | (394,309.9) | (194,810.0) | 199,499.9 |
| Нийт хөрөнгө | 517,203.3 | 600,389.7 | 83,186.4 |
| Өр төлбөр | - | 175.0 | 175.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 517,203.3 | 600,214.7 | 83,011.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 517,203.3 | 600,389.7 | 83,186.4 |

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй гарсан, өмнөх оны авлага 5,500.0 мянган төгрөгийг төлж барагдуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,586.1 мянган төгрөг болж өмнөх оноос 8,200.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 40,081.3 мянга, үнэ төлбөргүй 2,464.0 мянга, байгууллагын даргын 2021.12.27-ны өдрийн A/65 дугаартай тушаалаар 5,262.4 мянган төгрөгийн эргэлтийн материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 762,613.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 102,613.4 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 156 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 66 нэрийн 288,202,6 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хасаж, ашиглах хугацааг сунгаж, нийт 164,450.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон, ГЗБГЗЗГ-аас 3,039.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлсэн, техник хяналтын зардлаас 10,599.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Аудитаар цалинг давтан тооцоолоходо 175.0 мянган төгрөгийн өглөгийг ажилтанд буцаан олгоогүй, бүртгэл тайланд тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулснаар өглөг нэмэгдсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 83,011.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц данснаас 1,911.8 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 787,273.1 мянга, нийт зарлагыг 787,273.1 мянган төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 70,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ГЗБГЗЗГ-аас 218,221.7 мянган төгрөгөөр бууруулж 569,045.4 мянган төгрөгийн төсвийн баталсан ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,469.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 7,823.1 мянга нийт 31,292.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 537,752.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөв баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 569,045.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 557,389.5 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс 527261.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,127.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 527.261.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,124.6 мянга төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 552,779.2 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт төсөв 4,607.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт 70,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 75,773.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 552,779.2 мянган төгрөг байгаа нь цалингийн зардал 2,817.7 мянга, томилолтын зардал 1,334.9 мянга, бараа үйлчилгээний зардал 444.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны авлага 5,500.0 мянга, аймгийн ЗДТГ-аас өмнөх оны барилгын техник хяналтын зардлын тооцооны үлдэгдэл 4,123.7 мянга, Барилга хөгжлийн төвөөс 3,000.0 мянга, өөрийн орлого 23,834.1 мянган төгрөг оруулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 126 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 98.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна

### 3.8 Аудитын гол асуудал

Тайланд онд Egazar.gov.mn сайт болон egazar гар утасны аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшил, өмчлөл, ашиглалтын газарт газрын төлбөр, ногдуулалтыг үүсгэснээр газрын төлбөр, татвараа цахимаар төлөх нөхцөл хангагдаж, газартай холбоотой зөрчлийг арилгах зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор аймгийн ГХБХБГ нь 2021 онд 659,008.3 төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 323,203.6 мянган төгрөгийн 79 мэдээллийг мэдээлж, хуулийн 6.4.5-д заасан 2-8 сарын 333,804.7 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

**3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.. Үүнд:

- 2021 оны төсвийг Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 569,045.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 557,389.5 мянган төгрөг буюу 11,665.9 мянган төгрөгөөр бууруулан баталсан.

- Тайланд онд барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд сургалт, ГЗБГЗЗГ-аас сумдын даамлуудад байгууллагын даргын А/47, А/55 тушаалаар сургалт зохион байгуулан томилолт 6,735.0 мянга, хоол 4,401.0 мянга, бичиг хэргийн зардал 1,027.0 мянга нийт 12,163.0 мянган төгрөг зарцуулсан, тогтмол зардлыг 2021 оны төсөвт 23,469.8 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 22,304.5 мянган төгрөг буюу 5 хувийг хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны."Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5, 1.8 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь 2021 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, Аудитаар нийт 31630.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27031.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг бүрэн барагдуулж хэрэгжилтийг байгууллагын 2021.05.18 өдрийн 7/692, 2021.06.03-ны өдрийн 309 дугаарт албан бичгээр тус тус ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтээр шалгасан болно.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 15,866.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 175.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 15,691.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах давтан дахин гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэв.

**4.1 Залруулсан алдаа**

Цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг давтан тооцоолоход 2021 оны 7-р сард ШШГА-д шилжүүлэхээр 175.0 мянган төгрөгийг суутгасан ба тус ажилтны ШШГА-ын албадан

шилжүүлэх тогтоолын хугацаа дууссан тул суутгалыг суутгуулсан ажилтанд буцаан олгоогүй өглөгөөр бүртгээгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд ажилтанд өгөх 175,0 мянган төгрөгийн өглөгийг бүртгэн залруулав.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. <u>Илрүүлэлт</u>

Тайланд онд барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд сургалт, ГЗБГЗЗГ-аас сумдын даамлуудад байгууллагын даргын A/47, A/55 тушаалаар сургалт зохион байгуулан томилолт 6,735.0 мянга, хоол 4,401.0 мянга, бичиг хэргийн зардал 1,027.0 мянга нийт 12,163.0 мянган төгрөг зарцуулсан, тогтмол зардлыг 2021 оны төсөвт 23,469.8 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 22,304.5 мянган төгрөг буюу 5 хувийг хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны."Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5, 1.8 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна,

<u>Өгсөн зөвлөмж</u>

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

2. <u>Илрүүлэлт</u>

Баянхонгор аймгийн ГХБХБГ нь 2021 онд 659,008.3 төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн 6.4.5-д заасан 2-8 сарын 333804.7 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээг хуулийн хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянхонгор аймгийн ГХБХБГ | 3 | 15,866.7 | 1 | 175.0 | 0 | 0 | 0 | 0.0 | 2 | 15,691.7 |

---oOo---